



**ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 112

Шивээговь сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.3, 47 дугаар зүйлийн 47.1, Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ**:

1. Сумын 2024 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Сумын өвс тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Б.Болд-Эрдэнэ

(Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга)

Гишүүд:

Б.Хорол

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

А.Аасүрэн

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Няглан бодогч)

Хөндлөнгийн төлөөлөл:

Б.Базаррагчаа

(Сумын 1 дүгээр багийн иргэн)

Нарийн бичгийн дарга:

Д.Баттуул

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдаа авах

ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Үнэлгээний хорооны зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчийн гэрээний биелэлтэд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.СУГАРМАА

